



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 26 өдөр

Дугаар А/458

Ховд

Улсын Их Хурлын ээлжит сонгуультай  
холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.1 дэх хэсэг, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн санал авах, хяналтын тооллого хийхтэй холбогдуулан аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд 2024 оны 06 дугаар сарын 27, 28, 29-ний өдрүүдэд согтууруулах ундаагаар үйлчлэх, худалдахыг түр зогсоосугай.

2. Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн санал авах өдөр буюу 2024 оны 06 дугаар сарын 28-ны өдөр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллагуудад даалгасугай.


2.1. Соёл урлаг, үзвэр, спортын зэрэг олныг хамарсан аливаа арга хэмжээ зохион байгуулахгүй байхыг Соёл урлагийн газрын дарга (М.Пүрэвхүү), Биеийн тамир, спортын газрын дарга (Ч.Түмэндэмбэрэл), сумдын Засаг дарга нарт;

2.2. Гадаа болон битүү талбайд үйл ажиллагаа явуулдаг худалдаа, үйлчилгээний төвүүдийн тухайн 7 хоногийн амралтын өдрийг сонгуулийн санал авах өдөр буюу 2024 оны 06 дугаар сарын 28-ны өдөрт шилжүүлэн зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Жаргалант сумын Засаг дарга (Ц.Цогтбаяр)-д;

3. Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгжүүд, байгууллагыг мэдээллээр хангах, захирамжийн хэрэгжилтийг зохион байгуулж, биелэлтийг хангуулахыг аймгийн Цагдаагийн газрын дарга (цагдаагийн дэд хурандаа Г.Цоодол), сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Захирамжийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ч.Эрдэнэбат) даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



Х.БАТБОЛД

8400001 1117

Zah.A/458 Ba